**ГХБХБГ-ЫН 2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 1 ДЭХ ДОЛОО ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА**

2018.12.06

| 7 хоногийн ажлын товч мэдээлэл | Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал | Бусад асуудал |
|---|---|---|
| Газар өмчлөх эрхийг худалдах худалдан авах гэрээний үндсэн дээр шилжүүлж авахыг хүссэн 2 иргэний газар өмчлөх эрхийг шилжүүлж бүртгэлд оруулав.<br>Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хүссэн 1 иргэн, Газар эзэмших эрхийн гэрчилгээг хэсэгчлэн шилжүүлэхийг хүссэн 1 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг хүлээн авч аймгийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж ЗДТГ-рт хүргүүлэв.<br>“Өлгийланд” ХХК-ны хийсэн 18 иргэний, “Эл эм ланд” ХХК-ын хийсэн 2 газрын хэмжилтийн мэдээллийг хүлээн авч кадастрын мэдэллийн санд оруулсан болно.<br>Мөн сумдын даамлуудын үйлдэж өгсөн 9 газрын кадастрыг хянаж бүртгэлд оруулав.<br>Сумдын Газрын нэгдмэл сангийн 2018 оны тайланг хүлээж авч нэгтгэж байна.<br>2019 оны Аймгийн Газар Зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж ИТХ-ын ээлжит VIII-р чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.<br>БХБХСайдын аймгийн ЗД байгуулсан гэрээний биелэлтийг гаргаж ЗДТГакарт хүргүүлэв.<br>Буянт сумын халуун усны барилга, Өлгий сумын авто тээврийн хяналтын постын барилгын архитекторын төлөвлөлтийн даалгавар боловсруулж батлав.<br>Аймаг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний судалгаа гаргаж МХГазарт хүргүүлэв.<br>Аймгийн Хөгжийн драмын театрын засвар, Сагсай сумын 125 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг байнгын ашиглалтад авсан болно.<br><br>Сумдын газрын даамлын 2018 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг авч ажилласан аймгийн хэмжээгээр газрын төлбөрийн төлөвлөгөө 102,900,000 төгрөгөөр батлагдсанаас эхний 11 сарын байдлаар 88,641,100 төгрөг төвлөрч гүйцэтгэл нь 86 хувьтай байна. Газрын | | |

| | | |
|---|---|---|
| төлбөрийг хамгийн бага биелүүлсэн сумуудад Дэлүүн, Булган, Толбо сумууд орж байгаа бол хамгийн сайн биелүүлсэн сумуудад Алтанцөгц, Сагсай сумдад орж байна. | | |

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**